2025

ОСОЛ ГЭМТЭЛ ТАНДАЛТЫН ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ

III УЛИРАЛ

77115333-4
tandalt@gemtel.moh.gov.mn
www.gemtel.mn

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДОЛ, 2025 III УЛИРАЛ

Монгол Улсын хэмжээнд гэмтэл хордлого, гаднын шалтгаант өвчлөл, нас баралт сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа бөгөөд 2025 оны эхний 9 сарын байдлаар 170861 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9-иар өссөн байна.

Осол гэмтлийн шинэ тохиолдол



Осол гэмтэлд өртсөн тохиолдлын 60.3% (103030) нь эрэгтэй, 39.7% (67831) нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.

Осол гэмтэлд өртсөн тохиолдол хүйс, хувиар



Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, хувиар



Нийт тохиолдлын 10.4% (17790) нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна.

2025 оны эхний 9 сарын хугацаанд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 40.2% 0-18 насны хүүхдүүд байсан бөгөөд үүнээс 10-14 насанд хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна. Харин насанд хүрэгчид 59.8%-ийг эзэлж байна.

Осол гэмтлийн шинэ тохиолдол, насны бүлэг, хувиар



Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал хүмүүс гэртээ бэртэж гэмтэх тохиолдол хамгийн их хувийг эзэлж байна. Мөн сургууль, цэцэрлэг болон биеийн тамир спортын талбайд байхдаа гэмтэх тохиолдол түгээмэл байна.

Осол гэмтэлд өртөх үеийн байршил, хувиар



ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛИЙН ШАЛТГААН, 2025 III УЛИРАЛ



2025 оны эхний 9 сарын байдлаар осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан нь уналт (39.7%), амьгүй механик хүчинд өртөх (19.8%), зам тээврийн осол (14.3%), амьд механик хүчинд өртөх (8.7%), болон хүчирхийлэл (7.9%) байна.

ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

Осол гэмтэлд өртсөн сэдлээр харвал 89.4% нь санамсаргүйгээр осол гэмтэлд өртсөн бол 8.7% нь санаатайгаар өөрийгөө болон бусдыг гэмтээсэн тохиолдлууд эзэлж байна. Харин шалтгааныг тодруулах боломжгүй сэдэл тодорхойгүй осол гэмтэл 1.9% байна.

Осол гэмтлийн шалтгаан ӨОУА-10		Нийт	Хувь
Санамсаргүй осол гэмтэл			
W00-W19	Уналт	**67863**	**39.7**
W20-W49	Амьгүй механик хүчинд өртөх	**33829**	**19.8**
V01-V99	Зам тээврийн осол	**24456**	**14.3**
W50-W64	Амьд механик хүчинд өртөх	**14835**	**8.7**
W85-X19	Түлэгдэлт	5659	3.3
X40-X49	Санамсаргүй хордох, хорт бодист өртөх	3534	2
X50-X59	Бусад осол	1570	0.9
X30-X39	Байгалийн хүчинд өртөх	477	0.3
X20-X29	Хорт амьтан ургамалд өртөх	236	0.14
W75-W84	Амьсгал боогдох	212	0.1
W65-W74	Усанд унаж живэх	86	0.0
Санаатай үйлдлээс үүдсэн осол гэмтэл			
X85-Y09	Хүчирхийлэл	**13500**	**7.9**
X60-X84	Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах	1309	0.8
Сэдэл тодорхойгүй			
Y10-Y34	Тодорхойгүй осол	3295	1.9

ОСОЛ ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ОНОШ

Осол гэмтлийн улмаас тэргүүлж буй гэмтлийн оношоор харвал толгойн гэмтэл (21.6%), бугуй ба сарвууны гэмтэл (13.8%), шагай ба тавхайн гэмтэл (13.6%), тохой ба шууны гэмтэл (11.8%), болон өвдөг ба шилбэний гэмтэл (11.1%) байна.

Гэмтсэн эрхтний байршил		Нийт	Хувь
S00-S09	Толгойн гэмтэл	36886	21.6
S60-S69	Бугуй ба сарвууны гэмтэл	23527	13.8
S90-S99	Шагай ба тавхайн гэмтэл	23282	13.6
S50-S59	Тохой ба шууны гэмтэл	20229	11.8
S80-S89	Өвдөг ба шилбэний гэмтэл	18927	11.1
S20-S29	Цээжний гэмтэл	9786	5.7
S40-S49	Мөр ба бугалганы гэмтэл	9443	5.5
S30-S39	Хэвлийн гэмтэл	9127	5.3
T20-T32	Түлэгдэлт	5648	3.3
S70-S79	Түнх ба гуяны гэмтэл	5564	3.3
T51-T65	Эмийн бус бодисын хордлого	3368	2.0
S10-S19	Хүзүүний гэмтэл	1527	0.9
T15-T19	Биеийн сүвүүдээр орсон гадны биет	1097	0.6
T66-T78	Бусад тодорхойгүй нөлөөлөл	897	0.5
T36-T50	Эмийн бодис, эм, биологийн бэлдмэлийн хордлого	488	0.3
T90-T99	Хүндрэл	421	0.3
T00-T09	Биеийн олон хэсгийн гэмтэл	266	0.2
T33-T35	Хөлдөлт	238	0.1
T10-T14	Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл	132	0.1
T90-T98	Үлдэц	8	0.0

2025 оны III улиралд бүртгэгдсэн осол гэмтлийн нийт тохиолдлын 16.5% орон нутаг, 83.5% нийслэлд, байна. Харин нийслэлд бүртгэгдсэн тохиолдлын 94.9% ГССҮТөвийн ЯТТасгаас тусламж үйлчилгээ авсан байна.

2025 оны III улиралд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөл Архангай (2663), Дорноговь (2582), Өвөрхангай аймагт (2505) хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр аймагт (320) хамгийн бага бүртгэгдсэн байна. Бүсээр харвал төвийн бүсэд бусад бүстэй харьцуулахад тохиолдол их байна.

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 2025 ОНЫ III УЛИРАЛ

2025 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд гэмтэл, хордлого гадны шалтгаант 2407 нас баралт бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн байна. Харин 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин 2024 оны III улиралд 13.9 тохиолдол байсан бол 2025 оны III улиралд 1000 гэмтэл тутамд 14.1 буюу 0.2 тохиолдлоор өссөн байна.



Нийт нас баралтын 57.3 хувь */n=1378/* нь Улаанбаатар хотод, 42.7 хувь */n=1029/* нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Бүс, нутгаар харьцуулан үзвэл хангайн бүсэд нас баралт хамгийн өндөр байгаа бол Хөвсгөл, Төв, Сэлэнгэ аймгуудад осол гэмтлийн шалтгаант нас баралт бусад аймгуудаас өндөр бүртгэгджээ.

БҮРТГЭГДСЭН ГАЗАР	БОДИТ ТОО	ХУВЬ
БАРУУН БҮС /N=140/		
БАЯН-ӨЛГИЙ	26	1.1
ГОВЬ-АЛТАЙ	19	0.8
УВС	43	1.8
ХОВД	30	1.3
ЗАВХАН	22	0.9
ХАНГАЙН БҮС /N=415/		
АРХАНГАЙ	83	3.5
БАЯНХОНГОР	48	2.0
БУЛГАН	54	2.2
ХӨВСГӨЛ	110	4.6
ОРХОН	40	1.7
ӨВӨРХАНГАЙ	80	3.3
ТӨВИЙН БҮС /N=380/		
ДОРНОГОВЬ	83	3.5
ӨМНӨГОВЬ	38	1.6
ДУНДГОВЬ	29	1.2
СЭЛЭНГЭ	93	3.9

ТӨВ	94	3.9
ДАРХАН-УУЛ	33	1.4
ГОВЬСҮМБЭР	10	0.4
ЗҮҮН БҮС /N=94/		
ДОРНОД	36	1.5
СҮХБААТАР	21	0.9
ХЭНТИЙ	37	1.5
УЛААНБААТАР	**1378**	**57.3**
НИЙТ	**2407**	**100.0**

Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 79.0 хувийг */n=1901/* эрэгтэйчүүд, 21.0 хувийг */n=506/* эмэгтэйчүүд эзэлж байгаа ба эрэгтэйд 45-49 насанд, эмэгтэйд 35-39 насанд тохиолдлын тоо хамгийн өндөр байна.





Эрэгтэйчүүдийн 59.6 хувь */n=1133/* нь гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан бол эмэгтэйчүүдийн 41.1 хувь */n=208/* нь согтууруулах ундаа хэрэглэсэн байна.

ОСОЛ ГЭМТЛИЙН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:

1. Санамсаргүй хордох 30.0% *(n=722)*
2. Амиа хорлох 18.2% *(n=439)*
3. Зам тээврийн осол 17.5% *(n=420)*
4. Хүчирхийлэл 6.7% *(n=162)*
5. Уналт 6.3% *(n=152)*

2025 оны эхний 9 сарын байдлаар санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт тэргүүлж байгаа байна. Харин 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшинг шалтгаан тус бүрээр авч үзвэл усанд живэх, амьсгал боогдох, амиа хорлох шалтгаануудад өндөр байна.

ICD10	***Шалтгаан***	***Нийт тохиолдол***	***Нас баралт***	***Хувь***	***Үхлийн түвшин***
V01-V99	Зам тээврийн осол	24456	420	17.5	17.2
W00-W19	Уналт	67863	152	6.3	2.2
W20-W49	Амьгүй механик хүчинд өртөх	33829	36	1.5	1.1
W50-W64	Амьд механик хүчинд өртөх	14835	9	0.4	0.6
W65-W74	Усанд живэх	86	80	3.3	930.2
W85-X19	Түлэгдэлт	5659	47	2.0	8.3
X20-X29	Хорт амьтан ургамалд өртөх	236	1	0.04	4.2
X30-X39	Байгалийн хүчинд өртөх	477	154	6.4	322.9
X40-X49	Санамсаргүй хордох	3534	722	30.0	204.3
X60-X84	Амиа хорлох	1309	439	18.2	335.4
X85-Y09	Хүчирхийлэл	13500	162	6.7	12.0
Y10-Y34	Тодорхойгүй осол	3295	97	4.0	29.4
W75-W84	Амьсгал боогдох	212	83	3.5	391.5
X50-X59	Бусад	1570	5	0.2	3.2
Нийт		170861	2407	100.0	14.1

2025 оны эхний 9 сард бүртгэгдсэн нийт нас баралтыг онош буюу гэмтсэн эрхтний байршлаар авч үзвэл эмийн бус бодисын хордлого /спирт, угаарын хий гэх мэт/, бусад ба тодорхойгүй нөлөөлөл /гэмтлийн шок/ болон толгойн гэмтэл тэргүүлж байна.

ICD10	Гэмтсэн эрхтний байршил	Бодит тоо	Хувь
S00-S09	Толгойн гэмтэл	395	16.4
S10-S19	Хүзүүний гэмтэл	20	0.8
S20-S29	Цээжний гэмтэл	108	4.5
S30-S39	Хэвлийн гэмтэл	48	2.0
S40-S49	Мөр ба бугалгын гэмтэл	2	0.1
S50-S59	Тохой ба шууны гэмтэл	7	0.3
S70-S79	Түнх ба гуяны гэмтэл	19	0.8
S80-S89	Өвдөг ба шилбэний гэмтэл	7	0.3
T00-T09	Биеийн олон хэсгийн гэмтэл	141	5.9
T20-T32	Түлэгдэлт	40	1.7
T33-T35	Хөлдөлт	12	0.5
T10-T14	Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл	63	2.6
T15-T19	Биеийн сүвээр орсон гадны биет	10	0.4
T36-T50	Эм бэлдмэлийн хордлого	9	0.4
T51-T65	Эмийн бус хордлого	721	30.0
T66-T78	Бусад тодорхойгүй нөлөөлөл	708	29.4
T79-T88	Хүндрэл	95	4.0
T90-T99	Үлдэц	2	0.1
Нийт		2407	100.0

2025 оны III улиралд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралт Хөвсгөл (n=110), Төв (n=94), Сэлэнгэ аймагт (n=93) хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр аймагт (n=10) хамгийн бага бүртгэгдсэн байна. Бүсээр харвал хангайн бүсэд нас баралт өндөр байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд гарч буй нийтлэг алдаа

ГССҮТөвийн Статистик Тандалт Судалгааны албаны мэргэжилтнүүд харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь мэдээллийг тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрд нь хариу илгээдэг тул очсон и-мэйл-н дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү.

Дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийн маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу.

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь их байгаа учраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаа иргэдийн регистрийн дугаар болон насны бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү.
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, бүрэн дунд боловсролтой болон мэргэжил техник, дээд боловсролтой мөн ажил хөдөлмөр эрхэлдэг гэх мэт логик алдаа их гарч байна. Иймд боловсрол болон насны бүртгэлээ үнэн зөв эсэхийг нягталж хэвшинэ үү.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягтлан лавласны дараа бүртгэх, мэдээлэх.
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах.
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед “V”-тэмдэглэгээний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр зорчиж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой байдаг. Жишээ нь: “V”- тэмдэглэгээний ард 1 гэсэн бол эхний асуултад унадаг дугуйг гэсэн сонголтыг сонгоно гэсэн үг юм. Суудлын тэрэг бол “V”-ийн арын тоо 4 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед “V”-тэмдэглэгээний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-аар асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултад хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсгөөс унасан буюу V80.0-р кодлох ба 2-р эгнээний асуултад хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу ӨОУ-ын ангиллаар Дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Үүнд биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар авах нь буруу бөгөөд ӨОУ-ын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай

тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!

9. Хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь: Биеийн хүч хэрэглэн /гар, хөлөөрөө цохих зодох бол/-Y04, хутга болон иртэй зүйл хэрэглэсэн бол X-99, мохоо зүйл буюу сандал, ширээ, шүүр гэх мэт зүйл хэрэглэн халдсан бол-Y00, Өндрөөс бусдыг түлхэн унагаасан бол-Y01 гэм мэтээр халдлагад өртсөн зүйлээр нь тус бүрд өөрөөр кодолно.
10. Түлэнхийн шалтгаанаар /W85-X19/ тусламж авсан хүмүүст гэмтлийн оношийг T20-T32-н хооронд кодолно. Цахим санд бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй онош байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” баганад дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ үү. Мөн халууны үйлчлэлийн түлэгдэлд химийн түлэгдлийн онош тавихгүй байхыг анхаарна уу!
11. “Тусгай тэмдэглэл” хэсгийг заавал бөглөх ба энэ хэсэгт осол гэмтэлд хэрхэн өртсөнийг товч тодорхой бичнэ. Жишээ нь: *суудлын машинтай явж байгаад мотоциклтой мөргөлдсөн* гэх мэт.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРНА УУ.

Жишээ нь: Гэр бүлээрээ, ажлын байр, уул уурхай болон олноороо гал түймэрт өртөх, зам тээврийн осолд орох байгалийн гамшиг тохиолдох, барилга байгууламж, үйлдвэр, уул уурхай нурах гэх мэт осол гарах үед 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрд **tandalt@gemtel.moh.gov.mn** хаягаар болон 80081049, 99475896, 99021639, 88808674, 86620105 дугаарт мэдээлнэ үү! Та бүхний мэдээлж буй “Осол гэмтэл, нас баралтын тохиолдол” бүрийн үнэн, зөв байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгж болдгийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу. Хамтран ажиллаж байгаад баярлалаа.

Орон нутгийн эмнэлгүүдийн "ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ"-ийн мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			4 сар			5 сар			6 сар			7 сар			8 сар			9 сар			Нийт			Мэдээний зөрүү	Бааз ын зөрүү
		Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ		
1	Архангай	171	171	171	196	196	196	260	260	260	207	207	207	251	251	251	331	331	331	625	625	625	361	361	361	261	261	261	2663	2663	2663	0	0
2	Баян-Өлгий	125	125	125	102	102	102	73	73	73	115	115	115	82	82	82	38	38	38	46	46	46	32	32	32	57	57	57	670	670	670	0	0
3	Баянхонгор	85	85	85	77	77	77	142	142	142	149	149	149	133	133	133	183	183	183	178	179	178	189	189	189	118	118	118	1254	1255	1254	0	-1
4	Булган	98	98	98	105	106	106	94	94	94	90	90	90	150	150	150	133	133	133	113	113	113	85	85	85	78	78	78	946	947	947	1	0
5	Говь-Алтай	49	49	49	63	63	63	104	104	104	127	127	127	109	109	109	99	99	97	67	67	69	67	67	67	78	78	78	763	763	763	0	0
6	Говьсүмбэр	43	43	43	13	13	13	28	28	28	26	26	26	35	35	35	67	67	67	42	42	42	34	34	34	32	32	32	320	320	320	0	0
7	Дархан-Уул	219	219	219	252	252	252	159	159	159	148	148	148	192	192	192	84	84	93	377	378	377	135	135	135	26	26	17	1592	1593	1592	0	-1
8	Дорноговь	211	211	211	243	243	243	196	196	196	268	268	268	380	380	380	316	316	316	316	316	316	379	379	379	273	273	273	2582	2582	2582	0	0
9	Дорнод	90	97	90	108	101	108	120	120	120	125	125	125	149	149	149	149	149	150	160	160	160	139	139	137	131	131	131	1171	1171	1170	-1	-1
10	Дундговь	164	164	164	117	117	117	148	148	148	142	142	142	207	207	207	178	178	178	175	175	175	171	171	171	147	147	147	1449	1449	1449	0	0
11	Завхан	87	87	87	91	91	91	107	107	107	129	129	129	112	112	112	145	145	145	266	266	266	160	160	160	239	239	239	1336	1336	1336	0	0
12	Орхон	73	73	73	72	72	72	132	132	80	81	81	133	88	88	88	72	72	72	95	95	95	76	76	76	76	76	76	765	765	765	0	0
13	Өвөрхангай	234	234	234	149	149	149	233	233	233	261	261	261	364	364	364	234	234	234	420	420	420	352	353	352	257	257	257	2504	2505	2504	0	-1
14	Өмнөговь	156	157	156	127	127	127	101	101	98	116	116	116	148	147	148	140	140	140	164	164	164	175	175	174	195	195	195	1322	1322	1318	-4	-4
15	Сүхбаатар	104	103	104	118	118	118	121	121	121	130	130	130	112	112	112	127	127	127	201	201	201	162	162	162	132	132	132	1207	1206	1207	0	1
16	Сэлэнгэ	236	236	236	220	220	220	230	230	230	276	276	276	256	256	256	291	291	291	326	326	326	266	266	266	278	278	278	2379	2379	2379	0	0
17	Төв	170	170	170	147	147	147	208	208	208	177	177	177	230	230	230	275	275	275	323	323	323	274	274	274	178	178	178	1982	1982	1982	0	0
18	Увс	45	45	45	66	66	66	36	36	36	46	46	46	66	66	66	31	31	31	56	56	56	43	43	43	51	51	51	440	440	440	0	0
19	Ховд	61	61	61	24	24	24	37	37	37	55	55	55	45	45	45	39	39	39	36	36	36	34	34	34	38	38	38	369	369	369	0	0
20	Хөвсгөл	65	65	65	51	51	51	96	96	96	101	101	101	93	93	93	101	101	101	193	191	193	121	123	121	82	82	82	903	903	903	0	0
21	Хэнтий	136	137	136	110	110	110	104	104	104	138	138	138	126	127	126	189	188	189	180	180	180	138	138	138	167	167	167	1288	1289	1288	0	-1
	Нийт	2622	2630	2622	2451	2445	2452	2729	2729	2674	2907	2907	2959	3328	3328	3328	3222	3221	3230	4359	4359	4361	3393	3396	3390	2894	2894	2885	27905	27909	27901	-4	-8

Орон нутгийн эмнэлгүүдийн "ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ"-ын мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			4 сар			5 сар			6 сар			7 сар			8 сар			9 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ		
1	Архангай	11	11	11	8	8	8	6	6	6	6	6	6	7	7	7	11	11	11	10	10	8	9	9	10	16	15	16	84	83	83	-1	0
2	Баян-Өлгий	0	0	0	5	5	5	2	2	2	1	1	1	3	3	3	7	7	7	5	5	5	2	2	2	1	1	1	26	26	26	0	0
3	Баянхонгор	4	4	4	0	0	0	5	5	5	5	5	5	8	8	8	5	5	5	5	5	5	8	8	8	8	8	8	48	48	48	0	0
4	Булган	5	5	5	4	4	4	9	10	9	8	7	8	4	4	4	6	6	6	10	10	10	4	4	4	4	4	4	54	54	54	0	0
5	Говь-Алтай	2	2	2	0	0	0	1	1	1	3	3	3	4	4	4	2	2	2	5	5	5	2	2	2	0	0	0	19	19	19	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0	0	1	2	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	2	1	1	1	1	4	3	4	10	10	10	0	0
7	Дархан-Уул	3	3	3	6	6	5	5	5	5	6	6	7	3	4	3	4	3	4	2	1	2	4	4	4	1	1	1	34	33	34	0	1
8	Дорноговь	6	6	6	4	4	4	15	15	15	10	10	10	11	11	11	11	11	11	4	4	4	8	8	8	14	14	14	83	83	83	0	0
9	Дорнод	2	2	2	3	3	3	4	4	4	3	3	3	5	5	5	7	7	7	5	5	5	4	**2**	4	3	**5**	3	36	36	36	0	0
10	Дундговь	1	1	1	1	1	1	7	7	7	6	6	6	3	3	3	2	2	2	3	3	3	3	3	3	3	3	3	29	29	29	0	0
11	Завхан	2	3	2	5	4	5	2	2	2	1	1	1	3	2	3	2	2	2	1	1	1	3	3	3	4	4	4	23	22	23	0	1
12	Орхон	3	3	3	5	5	5	4	4	4	2	2	2	4	4	4	2	2	2	7	7	7	5	5	5	8	8	8	40	40	40	0	0
13	Өвөрхангай	5	5	5	9	9	9	11	11	11	5	5	5	6	6	6	8	8	8	10	10	10	8	8	8	18	18	18	80	80	80	0	0
14	Өмнөговь	1	4	1	6	6	6	7	5	7	4	4	4	4	4	4	5	4	5	3	3	3	3	3	3	5	5	5	38	38	38	0	0
15	Сүхбаатар	2	2	2	1	1	1	3	3	3	3	3	3	4	4	4	1	1	1	1	1	1	5	5	5	1	1	1	21	21	21	0	0
16	Сэлэнгэ	9	9	9	3	3	3	15	15	15	8	8	8	6	6	6	14	14	14	13	13	13	10	10	10	15	15	15	93	93	93	0	0
17	Төв	7	7	7	7	7	7	18	18	18	13	13	13	4	4	4	6	6	6	16	16	16	12	12	12	11	11	11	94	94	94	0	0
18	Увс	1	1	1	5	5	5	6	6	6	6	6	6	3	3	3	3	3	3	7	7	7	6	6	6	6	6	6	43	43	43	0	0
19	Ховд	2	2	2	2	2	2	4	4	4	2	2	2	4	4	4	2	2	2	3	3	3	5	5	5	6	6	6	30	30	30	0	0
20	Хөвсгөл	9	9	9	5	5	5	10	10	10	11	11	11	13	13	13	7	7	7	19	19	19	17	17	17	19	19	19	110	110	110	0	0
21	Хэнтий	5	5	5	2	2	2	1	1	1	3	3	3	6	6	6	4	4	4	4	4	4	6	6	6	6	6	6	37	37	37	0	0
	Нийт	80	84	80	81	80	80	136	136	136	107	106	108	106	106	106	110	107	110	134	134	132	125	123	126	153	153	153	1032	1029	1031	-1	2

Нийслэлийн эмнэлгүүдийн "ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ"-ийн мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			4 сар			5 сар			6 сар			7 сар			8 сар			9 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ		
1	УНТЭ	25	25	25	15	15	15	36	36	36	57	57	57	34	34	34	43	43	43	10	10	10	7	7	7	5	5	5	232	232	232	0	0
2	УХТЭ	6	6	6	6	6	6	2	2	2	7	7	7	9	9	9	7	7	7	14	14	14	7	7	7	1	0	1	59	58	59	0	1
3	УГТЭ	1	1	1	6	6	9	3	3	3	1	1	0	5	5	3	3	3	3	5	5	5	4	4	4	5	5	5	33	33	33	0	0
4	ЭХЭМҮТ	38	38	38	56	56	56	45	45	46	37	37	37	43	43	43	35	35	35	41	41	41	59	58	58	88	88	88	442	441	442	0	1
5	ГССҮТ	12532	12532	12532	11545	11545	11545	13848	13848	13848	14943	14943	14943	16936	16936	16936	15809	15809	15809	16176	16176	16176	16117	16116	16117	15612	15611	15612	133518	133516	133518	0	2
6	СЭМҮТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Мөнгөнгүүр	21	21	21	12	12	12	11	11	11	11	11	11	23	23	23	11	11	11	10	10	10	15	15	15	5	5	5	119	119	119	0	0
8	Интермед	9	9	0	20	20	29	12	12	12	18	18	18	16	16	16	10	10	10	7	7	7	8	8	8	10	10	10	110	110	110	0	0
9	МЯСЭ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	Асралт мед	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
11	MBG	0	0	0	3	3	0	6	6	0	3	3	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	13	13	0	-13	-13
12	ЦТЭ	316	316	316	203	203	203	266	266	266	229	229	229	256	256	256	210	210	210	210	210	210	252	252	252	302	302	302	2244	2244	2244	0	0
13	ТТАХНЭ	87	87	87	46	46	46	57	57	57	50	50	50	36	36	36	13	13	13	10	10	10	7	7	7	17	17	17	323	323	323	0	0
14	ТЗНЭ	0	0	0	0	0	0	0	0	0	2	2	1	0	0	0	0	0	0	2	2	2	0	0	0	0	0	0	4	4	3	-1	-1
15	ХТС	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	БГДЭМТ	1	1	1	0	0	0	0	0	0	8	8	8	1	1	1	0	0	0	7	3	7	4	4	4	4	4	4	25	21	25	0	4
17	БЗДЭМТ	45	45	45	52	52	52	48	48	48	25	25	25	19	19	19	15	16	12	10	23	10	6	20	6	19	60	19	239	308	236	-3	-72
18	БЗДНЭ	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	1	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	2	2	0	-2	-2
19	СБДЭМТ	2	2	2	1	1	1	1	1	1	0	0	0	4	4	4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	8	8	8	0	0
20	СБДНЭ	16	16	16	27	26	26	10	10	10	9	9	15	11	11	11	6	6	6	3	3	3	0	0	0			0	82	81	87	5	6
21	СХДЭМТ	1	1	0	0	0	0	1	1	0	4	4	6	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	1	1	0	8	8	7	-1	-1
22	СХДНЭ	4	4	4	5	5	5	6	6	6	15	15	15	15	15	15	33	33	33	40	40	40	11	11	11	10	10	10	139	139	139	0	0
23	ХУДЭМТ	61	61	61	100	100	100	93	93	93	117	117	117	110	110	110	92	92	92	35	35	35	0	0	0	115	115	115	723	723	723	0	0
24	ЧДЭМТ	60	60	60	58	56	56	60	58	58	70	70	74	56	56	56	51	50	51	32	32	32	38	38	38	46	46	46	471	466	471	0	5
25	ХУДНЭ	0	0	0	0	0	0	0	0	0	9	9	0	23	23	23	25	25	25	0	0	0	15	15	15	23	23	23	95	95	86	-9	-9
26	НАДЭМТ	30	30	30	28	28	28	15	15	15	20	20	20	18	18	18	82	82	82	75	75	75	100	100	100	35	35	35	403	403	403	0	0
27	БХДЭМТ	3	3	2	1	1	1	1	1	1	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	6	6	6	0	0
28	БНДЭМТ	40	40	40	56	56	56	154	154	154	110	110	110	192	192	192	101	101	101	107	107	108	23	23	23	51	51	51	834	834	835	1	1
29	Туул	0	0	0	3	3	3	3	3	3	2	2	2	6	6	6	4	4	4	2	2	2	7	7	7	4	4	4	31	31	31	0	0
30	Хонхор	3	3	3	0	0	0	5	5	5	2	2	2	4	4	4	3	3	3	0	0	0	0	0	0	0	0	0	17	17	17	0	0
31	Жаргалант	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
32	Гачуурт	5	5	5	3	3	3	2	2	2	4	4	4	2	2	2	2	2	2	6	6	6	5	5	5	4	4	4	33	33	33	0	0
33	Аддиктологи	25	25	25	21	21	21	31	31	31	9	9	9	17	17	17	9	9	9	18	18	18	11	11	11	13	13	13	154	154	154	0	0
34	Энэрэл	20	18	20	13	13	13	22	24	22	21	22	21	14	15	14	8	6	8	12	12	12	9	9	9	4	4	4	123	123	123	0	0
	Нийт	13351	13349	13340	12280	12277	12286	14738	14738	14730	15784	15784	15782	17850	17852	17848	16573	16571	16570	16834	16843	16833	16705	16717	16704	16375	16414	16374	140490	140545	140467	-23	-78

Нийслэлийн эмнэлгүүдийн "ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ"-ын мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			4 сар			5 сар			6 сар			7 сар			8 сар			9 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ		
1	УНТЭ	0	0	0	2	2	2	0	0	0	2	2	2	1	1	1	3	3	3	2	2	2	0	0	0	0	0	0	10	10	10	0	0
2	УХТЭ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	0
3	УГТЭ	4	4	4	3	3	3	3	3	3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	4	4	4	1	1	1	19	19	19	0	0
4	ЭХЭМҮТ	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	1	1	1	1	1	1	0	0	0	6	6	6	0	0
5	СЭМҮТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6	ГССҮТ	11	11	11	7	7	7	21	21	21	11	11	11	18	18	18	12	13	12	14	14	14	23	24	23	20	20	20	137	139	137	0	-2
7	ШШҮХ	152	152	152	89	89	89	119	119	119	134	134	134	140	140	140	119	119	119	131	131	131	115	115	115	120	120	120	1119	1119	1119	0	0
8	ЦТЭ	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	0	4	4	4	0	0
9	Грийн хоум	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	БГДЭМТ	5	5	5	0	0	0	2	2	2	1	1	2	0	0	0	0	0	0	4	4	0	2	3	7	1	1	7	15	16	23	8	7
11	БЗДНЭ	1	1	1	3	3	3	2	2	2	0	0	0	2	2	2	0	0	0	2	2	2	0	0	0	0	0	0	10	10	10	0	0
12	БЗДЭМТ	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1
13	СХДЭМТ	1	1	1	0	0	0	2	2	2	2	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	5	5	5	0	0
14	СХДНЭ	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	2	2	0	0
15	ХУДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	СБДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
17	СБДНЭ	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	1	1	1			1	7	7	8	1	1
18	ЧДЭМТ	0	0	0	2	2	2	2	2	2	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	5	5	5	0	0
19	НАДЭМТ	2	4	2	1	2	1	2	2	2	0	1	0	4	0	4	2	2	2	4	4	4	2	2	2	2	2	2	19	19	19	0	0
20	БХДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	БНДЭМТ	3	3	3	0	0	0	4	4	4	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	2	3	3	1	13	13	13	0	0
22	Гачуурт	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0
23	Энэрэл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
24	Аддиктологи	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0
25	ТЗНЭ	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0
		181	183	182	109	110	109	158	158	158	156	157	157	170	166	170	143	144	143	162	162	158	148	150	155	148	148	153	1375	1378	1385	10	7